United Nations
Educational, Scientific and
Cultural Organization

Diversity of
Cultural Expressions

2005 оны конвенцийн
Дэлхийн тайлан

ХУРААНГУЙ

СОЁЛЫН БОДЛОГЫГ ДАХИН ТОДОРХОЙЛОХ НЬ

Хөгжлийн төлөө бүтээлч
байдлыг хөгжүүлэх нь

2018

Өмнөх үг

Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай 2005 оны ЮНЕСКО-ийн конвенцийг хэрэгжүүлэхэд "Соёлын бодлогыг дахин тодорхойлох нь" хэмээх дэлхийн шинэ тайлан үнэлж баршгүй ач холбогдолтой.

Одоогийн байдлаар нийт 146 улсын соёрхон баталсан энэхүү конвенц нь соёлын үйл ажиллагаа, соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, үйлдвэрлэх, түгээн дэлгэрүүлэх чадавхийг сайжруулахад ЮНЕСКО-ийн хүчин чармайлтыг тэргүүлж байна. Соёлын болон бүтээлч үйлдвэрлэлийн салбаруудыг дорвитой хөгжүүлэхэд чиглэсэн төрийн бодлогыг хэрэгжүүлэх улсуудын бие даасан байдлыг хөхиүлэн дэмжихээс гадна энэ салбарт тогтвортой, илүү үр өгөөжтэй төрийн бодлогыг хэрэгжүүлэх үүргийг ЮНЕСКО хүлээнэ.

Бидний замын зураглал тодорхой бөгөөд төрийн болон төрийн бус байгууллагуудыг дараах дөрвөн гол салбарт хамтран ажиллахыг чухалчилдаг. Үүнд: соёлын засаглалыг бэхжүүлэх; уран бүтээлчдийн шилжилт хөдөлгөөний нөхцөлийг сайжруулах; соёлыг тогтвортой хөгжлийн стратегиудтай уялдуулах; хүний үндсэн эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжих. Эдгээр дөрвөн зорилго нь Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөртэй нягт уялдаа холбоотой.

Энэ тайлан анх 2015 онд хэвлэгдэн гарснаас хойш дэлхий дахинд соёлын бодлогод үнэлгээ, хяналт шинжилгээ хийж үзэхэд тодорхой байдлаар ахиц дэвшил гарсан байна. Үйл явцад дүн шинжилгээ хийхэд уран бүтээлийн эрх чөлөө, уран бүтээлчдийн шилжилт хөдөлгөөн, жендэр, олон нийтийн хэвлэл мэдээлэл, цахим бүтээлч байдал зэрэг стратегийн асуудлаар шинэ хандлагууд гарч ирсэн байна.

Шинэтгэн сайжруулж бүс нутгийн болон орон нутгийн түвшинд хэрэгжүүлсэн соёлын бодлогууд нь ерөнхийдөө соёлын засаглалд эерэг нөлөө үзүүлснийг энэ тайланд дурджээ. Түүнчлэн цахим орчинд хамгийн сайн тохирох стратегийн хамрах хүрээ, солилцооны хөтөлбөрийн үүсэл, Өмнөдийн уран бүтээлийн инкубаторын хөгжил хөдөлгөөнийг онцолсон. Мөн соёлын салбар дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл бага, үргэлжийн тэгш бус байдал, Өмнөдийн соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний худалдааны хүндрэл бэрхшээл, уран бүтээлчдийн бүтээн туурвих эрх чөлөөгөө алдах эрсдэл зэргийг бас хамруулсан. Энэ салбарт хараахан нийтлэгдэж амжаагүй статистик тоо баримт, мэдээллийг тусгаснаар соёлын салбарын хувьсан өөрчлөгдөж буй хэрэгцээнд тохируулан төрийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэхэд энэхүү тайлан чухал ач холбогдолтой юм.

Шведийн засгийн газар болон Шведийн Олон улсын хөгжлийн агентлагийн үзүүлсэн дэмжлэгт талархахын сацуу бүх гишүүн орнуудыг энэхүү анхдагч тайлангийн үр дүнг хүлээн авч соёлын үйл ажиллагаа, бүтээлч үйлдвэрлэлийг хүн төрөлхтний нэр хүнд, нийгмийн нягтрал, эдийн засгийн хөгжлийн хөдөлгөгч хүч хэмээн үзэж хөрөнгө оруулахыг урialж байна.

Одри Азулэй
ЮНЕСКО-ийн Ерөнхий захирал

Хураангуй

Анхны тайлан 2015 онд хэвлэгдэн гарснаас хойш ЮНЕСКО-ийн Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай 2005 оны конвенцийн хэрэгжилтийн хүрээнд гарсан ололт амжилтыг 2018 оны Дэлхийн тайланд задлан шинжилсэн. Энэ тайлан нь конвенцийн нарийн бичгийн дарга, түүний ажлын хамт олон, мөн ВОР-олон улсын зөвлөх байгууллагын зөвлөх бөгөөд ахлах редактортай хамтран ажилласан хараат бус 10 шинжээчдийн хамтын бүтээл юм.

Дэлхийн тайлан тус бүр нь оролцогч талуудаас (2011 онд конвенцийн оролцогч талуудын бага хурлаар батлагдсан журам) дөрвөн жил тутамд ирүүлдэг хугацаат тайлангуудад хийсэн дүн шинжилгээнд тулгуурласан. Энэхүү дэлхийн тайланг бэлтгэхийн тулд зохиогчид 2015 оноос хойш оролцогч талуудаас ирүүлсэн 62 хугацаат тайланд дүн шинжилгээ хийхийн сацуу бусад эх сурвалжийн холбогдох шинэ баримтуудыг авч хэлэлцсэн. Түүнчлэн өөрсдийн туршлага, шинжээчийн ур чадвараа дайчлан ажилласан болно.

Конвенцийн нарийн бичгийн дарга болон ахлах редакторын танилцуулгад энэхүү дэлхийн тайлангийн урт хугацааны зорилго болон конвенцид тусгагдсан тэргүүлэх зарчим, үнэт зүйлсийг тусгаснаас гадна 2015 онд анх гаргаснаас хойш конвенцийн хэрэгжилтийн нөлөөллийг хянан шинжлэх арга зүйн хүрээний гол хэсгүүдийг тайлбарласан. Энэ хүрээ нь дараах дөрвөн гол зорилгоос бүрдэнэ. Үүнд:

Goal 1 СОЁЛЫН ЗАСАГЛАЛЫН ТОГТВОРТОЙ ТОГТОЛЦООГ ДЭМЖИХ

Goal 2 СОЁЛЫН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЭНЦВЭРТ УРСГАЛЫГ ХАНГАХ, СОЁЛЫН МЭРГЭЖИЛТЭН, УРАН БҮТЭЭЛЧДИЙН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

Goal 3 СОЁЛЫГ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХҮРЭЭТЭЙ УЯЛДУУЛАХ

Goal 4 ХҮНИЙ ҮНДСЭН ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ ХАНГАХ

Эдгээр зорилгыг Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөртэй уялдуулж дэлхийн тайланг урт хугацаандаа бодлогын яриа хэлэлцээ, өөрчлөлтөд шинэ орон зайг бий болгох үр нөлөөтэй арга хэрэгсэл байх болно хэмээн газрын зураглалын үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлсон.

Эхний бөгөөд тэргүүлэх зорилго бол ТХЗ 8, 16, 17-г хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах соёлын засаглалын тогтвортой тогтолцоог дэмжих явдал юм. Энэ сорилтыг дэлхийн тайлангийн эхний хэсгийг бүрдүүлэх дөрвөн бүлэгт багтаасан. Эдгээр бүлгүүдийн эхний хэсэгт соёлын илэрхийллийн олон төрлийг хөхиүлэн дэмжих бодлого, арга хэрэгслийг нарийвчлан авч үзэн хэд хэдэн гол санаануудыг уншигчидтайгаа хуваалцдаг. Конвенциор өсөн нэмэгдэх зүйл тогтол, үнэндээ соёлын бодлогыг батлах чин эрмэлзэл, өөрчлөгдөн буй цаг үед тохируулах зэргийг тодорхой тогтоож өгснийг зохиогч олж илрүүлсэн. Конвенцийг хэрэгжүүлснээр хамтын засаглал, олон талт шийдвэр гаргах үйл явцад эерэг нөлөө үзүүлж эхэлсэн төдийгүй энэ нь хөгжиж буй зарим оронд, бүтээлч эдийн засаг, соёлын боловсролын салбарт мэдрэгдэж эхэлсэн. Соёлын бодлогын тодорхой инновациудыг бүс нутгийн болон орон нутгийн удирдлагууд өөрийн

бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлж байна. Ялангуяа хөгжиж буй орнуудад бодлогын хэрэгжилт, соёлын бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээний санхүүжилт болон үзэгчдийн орон нутагт үйлдвэрлэсэн контентыг үзэх боломж нь хоорондоо харилцан хамааралтай байна.
Хэдий тийм боловч үр дүнд үнэлгээ, дүн шинжилгээ хийх явдал цөөн байгаагаас мэдээллийн хүртээмж хангалтгүй болж улмаар соёлын илэрхийллийн олон төрлийг дэмжихэд соёлын бодлого үр нөлөөтэй эсэхэд үнэлгээ хийхэд хүндрэл гарч байна.

Энэ хэсгийн хоёр дахь бүлгийг **олон нийтийн хэвлэл мэдээлэлд,** өндөр чанартай соёлын контентыг үйлдвэрлэгч, төлөөлөгч, түгээгч, нийтлэгч, зуучлагч нарт зориулсан. Засгийн газрууд олон нийтийн хэвлэл мэдээллийн бодлого, тогтолцоогоо шинэчилдэг учраас хэвлэл мэдээллийн эрх чөлөө, олон талт байдлын асуудлаар хууль эрх зүйн зохицуулалтын хувьд бодит сайжруулалт нэлээд гарсныг зохиогч олж тогтоосон. Тэрээр төрийн үйлчилгээ, хувийн хэвлэл мэдээлэл дэх бүтээлч байдал, олон талт байдал зэргийг одоогоор дэлхийн 90 гаруй оронд хэрэглэж байгаа квотын зарчмаар нэмэгдүүлж байгааг дурдсан. Цахим орчинд тохируулсан бодлогын шинэ хүрээ нь босоо болон хэвтээ хэвлэл мэдээллийн хэрэгслийн нийлэмжийн сорилтод хариулт өгөх эхлэл юм. Гэсэн хэдий ч ялгаа оршсоор байна. Бүх хувь хүн, бүлгийн хэрэгцээнд үйлчилж олон нийтийн бодол санааны өөрчлөлт, нийлэмжийн үйл явцад хариулт өгөх ирээдүй рүү чиглэсэн олон нийтийн хэвлэл мэдээллийн бодлогын загвар хэрэгтэй байгаа нь ажиглагдсан.

Үнэн хэрэгтээ, технологийн хувьсгал нь хэвлэл мэдээллийн засаглал болон соёлын бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээний бүх асуудалд нэлээдгүй нөлөө үзүүлсэн. Гурав дахь бүлэгт хурдацтай өөрчлөгдөж буй **цахим орчны** ойлголтод дүн шинжилгээ хийсэн. Соёлын бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээ нь дамжуулах хоолой шиг тохиргооноос сүлжээний загварт шилжсэн бөгөөд цөөн хэдэн орон эдгээр өөрчлөлтэд зохицсон стратегитай байна. Хэдхэн оролцогч талууд соёлын бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээний тусгай зангилааг сайжруулах, эсхүл цахимжуулахын тулд авч хэрэгжүүлсэн санаачлагуудаас гадна соёлын цахим бодлогыг боловсруулж хэрэгжүүлсэн. Өмнөдөд гар утасны өргөн зурвасын олон тооны ашиглалтаас улбаатай давуу тал байдаг хэдий ч олон оронд дэд бүтэц байхгүй, цахим аргаар үйлдвэрлэж тараасан соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлийг бий болгох боломжгүй байна. Том платформ гарч ирснээр зах зээлийн анхаарлыг татаж төрийн статистикийг сулруулж хуурамч оюун санааны монополийг бий болгосон. Эдгээр эрсдэлтэй тэмцэх зорилтот арга барилгүйгээр төрийн салбар бүтээлч талбарын агентлагаа бүхэлд нь алдаж болзошгүй юм. Тиймээс төрийн салбар, хувийн хэвшил, иргэний нийгмийн хооронд бүхэлдээ шинэ төрлийн харилцаа шаардлагатай бөгөөд тэр нь харилцан хамаарал, хамтын ажиллагаа, бодлогын хүрээг дахин байгуулах зэрэгт суурилсан харилцаа байна гэдгийг зохиолч хөндсөн байна.

Энэ утгаараа конвенц нь соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэлт, түгээлт шиг нарийн төвөгтэй хэсгийн бодлогын хэрэгжүүлэлтэд хувь нэмрээ оруулж буй **иргэний нийгмийн** оролцогчдод ач холбогдол өгдөг манлайлагч хэлэлцээр хэвээр байна. Дөрөвдүгээр бүлэгт соёлын засаглалын тогтвортой тогтолцоог дэмжих конвенц нь зөвхөн иргэний нийгмийн оролцоо хүчтэй байгаа цагт зорилгодоо хүрч чадна гэдгийг онцолсон. Гэхдээ иргэний нийгмийн олон оролцогчид шийдвэр гаргах үйл явц ил тод биш байгаа бөгөөд тийм оролцоог хууль, тогтоомжоор хангалттай дэмжихгүй байгаа гэдэгт итгэж байна. Хэдийгээр эдгээр сорилтууд байгаа ч иргэний нийгмийн байгууллагуудын хүчтэй цөм нь соёлын засаглалыг сайжруулах, соёлын бодлогыг хөгжүүлэхэд гол үүрэгтэй хэвээр байна. Иргэний нийгмийн оролцогчид өөрийн хамтран ажиллагчдаа татан оролцуулах, сурталчилгаанд оролцох, мэдлэг бий болгох, түгээх, шинэ сүлжээг бий болгох зэргээр конвенцийг хэрэгжүүлж байна. Шийдвэр гаргах түвшинд хангалттай хэмжээнд оролцохын тулд бодлогын оролцоо, харилцаа холбоо, сүлжээний асуудалд анхаарч иргэний нийгмийн чадамж, нөөцийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх шаардлагатай.

Тайлангийн хоёр дахь хэсэг нь ТХЗ 8, 10-ыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх **соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний тэнцвэрт урсгал болон соёлын мэргэжилтэн, уран бүтээлчдийн шилжилт хөдөлгөөнийг дэлхийн дахинд хангах** зэрэг зорилтуудтай холбоотой.

2015 оны тайланд дурдсаны нэгэн адил **соёлын мэргэжилтэн, уран бүтээлчдийн шилжилт хөдөлгөөн** нь үнэт зүйлс, үзэл бодлын олон янзын ертөнц, дэлхийн үзэл санааг дэмжих, соёлын болон бүтээлч үйлдвэрлэлийг дэлгэрүүлэхэд чухал юм. Тав дахь бүлэгт энэ талаарх дэлхий дахины төлөв байдалд дүн шинжилгээ хийсэн. Умард нь Өрнөдийн уран бүтээлч, соёлын ажилтнуудын гол зах зээл хэвээр байсаар байгаа бол одоогийн аюулгүй байдлын орчинд эдгээр гол цэгт хүрэх нь үнэхээр төвөгтэй болж байна. Өрнөд болон Умардын хооронд шилжилт хөдөлгөөн хийхэд байнга гарч буй тэгш бус байдлыг арилгахад визийн журам иргэний нийгэм, соёлын байгууллагуудын хүчин чармайлтыг талаар болгож байна. Уран бүтээлчдийн чөлөөт шилжилт хөдөлгөөн, хөдөлгөөний эрх чөлөөнд гарч буй хязгаарлалтуудыг цензурын хэрэгсэл болгон ашиглаж байна. Өмнөд-Өмнөдийн шилжилт хөдөлгөөнд гарч буй шинэ ашиг сонирхлын

хамт зах зээлд нэвтрэх, үндэстэн дамнасан соёлын хамтын ажиллагааны хүрээнд шилжилт хөдөлгөөн хийх боломж өсөн нэмэгдэж байна. Өмнөдөд институцийн цар хүрээ болон санхүүжилтийн бүтэц хангалтгүй байгаа хэдий ч бүс нутгийн хэмжээнд шинэ сүлжээ, солилцооны хөтөлбөр, бүтээлч кластер дэлгэрсээр байна. Энэ нь олон янзын, хараат бус урлагийн салбартай нягт холбоотой.

Зургаадугаар бүлэгт соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний урсгалтай холбоотой хамгийн сүүлийн үеийн чиг хандлагыг авч үзсэн. Бүх хөгжиж буй орнууд, түүний дотор Хятад, Энэтхэгийг оролцуулан соёлын бүтээгдэхүүний урсгалын өсөн нэмэгдэж буй хэсгийг төлөөлж, дэлхийн соёлын бүтээгдэхүүний худалдаа 2005 онд 25% байсан бол 2014 онд 45% байгааг зохиогч олж илрүүлжээ. Ололт амжилт гарсан байна. Гэхдээ Умардын соёлын бүтээгдэхүүний зах зээлд хөгжиж буй орнуудад нэвтрэхэд худалдааны саад тотгор, хөнгөлөлтийн таатай бус нөхцөл, боловсон хүчний болон санхүүгийн хязгаарлагдмал байдал хэвээр байна. Голдуу дуу, дүрс бичлэгийн салбарт цахим түгээлтийн хөтөлбөр, солилцооны сүлжээ, экспортын стратеги байгаа зэрэг нь Өмнөдийн орнуудад соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний олон улсын зах зээлд нэвтрэхэд дэмжлэг болж байна. Орон нутагт квот тогтоох нь үндэсний дуу, дүрс бичлэгийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх үр өгөөжтэй арга бөгөөд ялангуяа экспортыг нэмэгдүүлэхэд нөлөө үзүүлж байна. Түүнчлэн энэ бүлэгт нотолгоонд суурилсан бодлого, худалдааны хэлэлцээрийг дэмжихийн тулд цахим шинэ орчин дахь соёлын худалдаа үйлчилгээний талаарх мэдээлэл бүрдүүлэлтийг сайжруулахыг шаардаж байгаа нь 3 дугаар бүлгийн ололтыг бататгасан.

Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай конвенцийн бусад олон улсын эрх зүйн гэрээ, хэлэлцээр, тухайлбал, худалдааны талбар дахь нөлөөллийг тооцох хэрэгтэй. Энэ талаар долоодугаар бүлэгт авч үзсэн. Том бүс нутгийн түншлэлийн хэлэлцээрт энэ конвенцийг дэмжих талаар бараг дурдаагүй бол 2015-2017 оны хооронд хийгдсэн хоёр талын болон бүс нутгийн чөлөөт худалдааны 8 хэлэлцээрийн хувьд талууд соёлын нөхцөл буюу үүрэг даалгаврын жагсаалтыг гаргасан нь гол дүгнэлт болно. Соёлын хамтын ажиллагааны талаар шинэ протоколд 2015-2017 оны хооронд гарын үсэг зураагүй бол чөлөөт худалдааны бусад гэрээнд өргөн нэвтрүүлгийн болон дуу, дүрс бичлэгийн салбарт хөнгөлөлтийн журмыг нэвтрүүлэх заалтуудыг тусгасан байна. Конвенцийн оролцогч талууд дуу, дүрс бичлэгийн салбар, эсхүл худалдааны хэлэлцээрт соёлын бусад үйлчилгээг оруулахыг гол төлөв санал болгожээ. Европын холбоо болон бүс нутгийн бусад байгууллагууд конвенцтэй холбоотой асуудалд чиглэсэн чухал алхмуудыг авч хэрэгжүүлсэн бөгөөд нэн ялангуяа цахим асуудал, тогтвортой хөгжил, соёлыг үндэсний худалдааны хүрээтэй уялдуулах зэрэгт анхаарал хандуулсан байна.

2015 онд дурдсан конвенцийн хэрэгжилтийн 3 дахь зорилго бол ТХЗ 4, 8, 17-г хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах соёлын хүрээг тогтвортой хөгжлийн цар хүрээтэй уялдуулах урт хугацааны ажлыг урагшлуулах байв.

Найм дахь бүлэгт конвенцийн хэрэгжилт тогтвортой хөгжлийн хүрээнд хэрэгжиж буй бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрт хэрхэн эерэг нөлөө үзүүлснийг авч үзсэн. Үндсэндээ, тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөрт тогтвортой хөгжилд соёлын гүйцэтгэх үүргийг таниулахад нөлөөлсөн. Олон улсын тогтвортой хөгжлийн хэд хэдэн хөтөлбөрт соёлын асуудлыг гол хэсэг гэж авч үздэг ч соёл болон амралтад зарцуулсан хөгжлийн тусламжийн хувь хэмжээ өнгөрсөн 10 жилтэй харьцуулахад доогуур үзүүлэлттэй байна. Үндэсний хөгжлийн төлөвлөгөө буюу стратеги баталсан 111 оролцогч талуудын зарим 96 нь зөвхөн соёлын хүрээний заалтуудыг оруулсан. Эдгээрийн гуравны хоёроос илүү нь Өмнөдийн орнууд юм. Эдгээр орнууд соёлын хүрээг эхний ээлжинд эдийн засаг, нийгмийн хөдөлгөгч хүч гэж авч үзсэн бол үндэсний хөгжлийн төлөвлөлтийн баримт бичгийн зөвхөн 40% конвенцийн зорилготой холбоотой үр дүн, үйл ажиллагааг агуулсан. Бас нэгэн асуудал бол соёлын бүтээгдэхүүн, уран бүтээлийн ажлын байгаль орчны нөлөөллийг хангалттай хэмжээнд авч үзээгүй. Гэхдээ энэ чиглэлээр орон нутгийн удирдлагууд шинэ чиглэлд ажиллаж байгааг дурдах нь чухал юм. Дэлхийн хотууд соёлын болон бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлж тогтвортой хөгжлийг дэмжих шинэ арга замуудыг нэвтрүүлж байна.

Тайлангийн төгсгөлийн хэсэгт ТХЗ 5 болон 16-г хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах харилцаа холбоо, мэдээлэл болон сүүлийн жилүүдэд хамгийн чухалд тооцогдох хүний үндсэн эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжих тухай конвенцийн гол зарчимд үндэслэсэн.

Жендэрийн тэгш байдал нь гол хэмжүүр бөгөөд конвенцийн хувьд жендэрийн тэгш байдлыг хангах бодлого, арга хэрэгслийг шаардах, эмэгтэйчүүдийг соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ-үйлдвэрлэгч, уран бүтээлч хэмээн дэмжихийг чухалчилсан. 2015 оны дэлхийн тайланд дэлгэрэнгүй дурдсан сэдэв болох дэлхийн ихэнх хэсэгт, соёлын бүх хүрээнд орших жендэрийн олон талт ялгаатай байдлын талаар ес дэх бүлэгт авч үзсэн.

Эмэгтэйчүүдийн төлөөлөл ажлын байранд, нэн ялангуяа гол дүр бүтээх, шийдвэр гаргах түвшинд бага байгаад зогсохгүй тэдний нөөц бололцоог хүртэх хүртээмж сул, эрэгтэйчүүдээс доогуур цалин хөлс авч байна. Ийм зөрүүтэй байдлыг зөвхөн ойлгоод зогсох бус, харин соёлын илэрхийллийн олон төрлөөр дамжуулан бодит үйл хэрэг болгохыг ухамсарлан шийдвэрлэх хэрэгтэй. Энэ бүлгийн зохиогч нь соёлын илэрхийллийг бүтээгч, үйлдвэрлэгч, түгнчлэн иргэдийн дунд соёлын амьдралын хүртээмж, оролцооны үүднээс жендэрийн тэгш байдлыг идэвхийлэн дэмжихгүйгээр конвенцийг зохистой хэрэгжүүлэх боломжгүй гэдгийг цохон тэмдэглэсэн. Үүнд тусгай арга хэрэгслээс гадна жендэрийн үзэл санааг соёлын бүх бодлого, арга хэрэгсэлд тусгах нь адил хэмжээнд чухал гэдгийг дурдахгүй байж болохгүй. Хүйсээр зааглан системтэй бүрдүүлсэн үндэсний болон дэлхийн мэдээллийн бааз байхгүй хэдий ч энэ талбарт нөхцөл байдлыг тодорхойлж, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлж, бодлого, төлөвлөгөөг танилцуулж үйл явцад хяналт шинжилгээ хийхийн тулд ийм төрлийн мэдээлэл зайлшгүй шаардлагатай. Хэрэв эмэгтэйчүүд соёлын амьдралын бүх хэсэгт бүтээгч, үйлдвэрлэгч, мөн иргэн, хэрэглэгчийн хувьд оролцох боломжгүй тохиолдолд соёлын илэрхийллийн олон төрлийг ойлгоход бэрхшээл үүснэ.

Сүүлийн бүлгийг зөвхөн уран бүтээлчдийн бүтээлч байдал бус, мөн соёлын бүх үйлдвэрлэгч, үзэгчдийн эрхтэй холбоотой уран бүтээлийн эрх чөлөөнд зориулсан. Өнөөдөр энэ эрх чөлөө нь төрийн болон төрийн бус байгууллагын олон хүчин зүйлсээс шалтгаалж хязгаарлагдмал байна. Энэ бүлэгт төрийн болон төрийн бус оролцогчдын зүгээс 2016 онд уран бүтээлийн эрх чөлөөнд халдсан тохиолдол ихэнхдээ хөгжимчдийн эсрэг гарсан нь 2014, 2015 онтой харьцуулахад тодорхой хэмжээгээр нэмэгдсэнийг дурдсан. Уран бүтээлийн илэрхийллийг амжилттай хамгаалах болон хөхиүлэн дэмжихэд уран бүтээлийн эрх чөлөө чухал болохыг ойлгуулахад ахиц дэвшил гарсан. Зарим улс орнууд энэхүү үндсэн эрх чөлөөг хүндэтгэн үзэж эрх зүйн зохицуулалт хийхээр үүрэг амлалт ч авсан. Уран бүтээлчдийн нийгэм, эдийн засгийн эрхийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээг үндэсний хууль тогтоомжид тусгах явдал нэмэгдэж, нэн ялангуяа Африкт өсөж буйг энэ бүлэгт онцлон тэмдэглэсэн. Үүний зэрэгцээ терроризм, үндэсний аюулгүй байдал, гүжирдлэг, шашин, уран бүтээлийн болон чөлөөт илэрхийллийн хэлбэрийг тогтооход хэрэглэдэг уламжлалт үнэт зүйлстэй холбоотой хуулиуд багтана. Оролцох байгууллагуудын тоо, чадамж АНУ-д хүртэл өсөж буй тул урлагийн эрх чөлөөг хянан шинжлэх, сурталчлах ажил нэмэгдсэн. Энэ хүрээнд, бүтээн туурвих эрх чөлөөгөө алдах эрсдэлд орсон уран бүтээлчдэд урлагаа чөлөөтэй илэрхийлэх боломж бүрдсэн байгууламжуудыг бий болгоход хотууд дорвитой арга хэмжээ авч байгаа бөгөөд дэлхийд 80 гаруй тус чиглэлийн байгууламжууд бий болсон байна.

Энэхүү дэлхийн тайланд дурдсан дүн шинжилгээний хамт оролцогч талуудын тайлагнасныг авч үзэхэд конвенц соёлын илэрхийллийн олон төрлийн тусын тулд шийдвэр гаргах халхавчийг зузаатгаж өгсөн гэж үзэж байна. Конвенцийн заалтуудын ил тод байдал, мэдээллийг солилцоход илүү ихээр хувь нэмэр оруулдаг хяналт шинжилгээ, үнэлгээний механизмыг бий болгохыг оролцогч талуудад тодорхой болгож өгсөн. Гарсан ахиц дэвшил, инновацийг тайлагнасан нь конвенцийг хэрэгжүүлэх анхны суурь нотолгоонд хувь нэмэр оруулж, ТХЗ-уудын хэрэгжилтийг мэдэх боломж олгож байгаа тул ихээхэн найдвар төрүүлж байна. Гэхдээ тэднийг хангалттай гэж хэлэхэд төвөгтэй байна. Конвенцийн гол үзүүлэлтүүд болон ТХЗ-уудын жагсаалтын хамт дэлхийн үүрэг амлалтуудыг мэдээлэх нотолгоог бий болгохоос гадна тогтвортой хөгжлийн үр дүнг бий болгох бүтээлч байдалд хөрөнгө оруулж, соёлын илэрхийллийн олон төрлийг хэрхэн дэмжих талаар хамтын ойлголтыг бий болгоно.

Ирэх жилүүдэд оролцогч талууд энэхүү дэлхийн тайланд дурдсан шаардлагуудыг бүхэлд нь биш юмаа гэхэд хүртээмжтэй аргаар хангаж чадсан тохиолдолд дэлхий дахинд соёлын бодлогыг дахин зөв тодорхойлох зорилго бүхий 2005 оны конвенцийн урт хугацааны амлалтыг биелүүлэх үйл явцтай холбогдоно.

СОЁЛЫН ИЛЭРХИЙЛЛИЙН ОЛОН ТӨРЛИЙГ ХАМГААЛАХ БОЛОН ХӨХИҮЛЭН ДЭМЖИХ ТУХАЙ 2005 ОНЫ КОНВЕНЦИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

ТЭРГҮҮЛЭХ ЗАРЧМУУД	Ил тод, мэдээлжсэн, оролцооны үйл явц бүхий засаглалын тогтолцоонд тулгуурлан соёлын илэрхийллийн олон төрлийг хөхиүлэн дэмжих бодлогыг баталж хэрэгжүүлэх улсуудын хараат бус бүрэн эрх баталгаажсан байна			
ЗОРИЛГО	**СОЁЛЫН ЗАСАГЛАЛЫН ТОГТВОРТОЙ ТОГТОЛЦООГ ДЭМЖИХ**			
ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН	Соёлын олон төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг бүтээх, үйлдвэрлэх, түгээх, хүртэх эрхийг хөхиүлэн дэмжиж ил тод, мэдээлжсэн, оролцооны тогтолцоо бүхий соёлын засаглалд хувь нэмэр оруулахад чиглэсэн үндэсний бодлого, арга хэмжээг хэрэгжүүлнэ			
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭСЭГ	***Соёлын бодлого***	***Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл***	***Цахим орчин***	***Иргэний нийгмийн түншлэл***
ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД	Соёлын олон төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг бүтээх, үйлдвэрлэх, түгээх, хүртэх эрхийг үндэсний соёлын бодлогоор дэмжинэ	Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, олон янз байдлыг хууль эрх зүйн хүрээнд дэмжинэ	Соёлыг цахим орчинд дэлхий нийтэд танилцуулах ажлыг эрх зүйн хүрээнд дэмжинэ	Иргэний нийгмийн хууль эрх зүйн болон зохицуулалтын хүрээг бий болгоно
	Төрийн салбарын олон агентлагуудыг бодлого боловсруулахад татан оролцуулна	Олон нийтийн хэвлэл мэдээллийн зорилгыг хууль эрх зүйн хувьд тодорхойлж баталгаажуулна	Цахим бүтээлч байдал, цахим орчин дахь иргэний нийгмийн оролцоог бодлого, арга хэмжээгээр дэмжинэ	Бодлого боловсруулж хэрэгжүүлэхэд иргэний нийгэм оролцох чадамжтай байна
	Мэдээлжсэн бодлого боловсруулах үйл явцыг оролцогч талууд идэвхтэй дэмжинэ	Олон нийтийн хэвлэл мэдээллийн бодлого, үйл ажиллагаа нь нийгмийн бүх бүлгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байна	Эрч хүчтэй, олон талт соёлын үйлдвэрлэлийн цахим зах зээлийг бодлого, арга хэмжээгээр дэмжинэ	Иргэний нийгэм конвенцийн засаглалд үндэсний болон дэлхийн түвшинд идэвхтэй оролцоно

Соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний урсгалын нээлттэй, тэнцвэрт байдал, тэгш хүртэх эрх болон соёлын мэргэжилтэн, уран бүтээлчдийн чөлөөт хөдөлгөөнд дэмжлэг үзүүлнэ	Тогтвортой хөгжлийн эдийн засгийн болон соёлын цогц байдлыг хүлээн зөвшөөрнө	Хүний үндсэн эрх, эрх чөлөөний илэрхийлэл, мэдээлэл, харилцаа холбоог хүндэтгэн соёлын илэрхийллийн олон төрлийг бүтээх, түгээн дэлгэрүүлэх урьдач нөхцөл хэмээн баталгаажуулна
СОЁЛЫН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЭНЦВЭРТ УРСГАЛЫГ ХАНГАН СОЁЛЫН МЭРГЭЖИЛТЭН, УРАН БҮТЭЭЛЧДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙГ НЭМЭГДҮҮЛНЭ	**СОЁЛЫГ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХАМРАХ ХҮРЭЭНД НЭГТГЭНЭ**	**ХҮНИЙ ҮНДСЭН ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ ХӨХИҮЛЭН ДЭМЖИНЭ**
Соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний тэнцвэрт урсгалыг хангах болон соёлын мэргэжилтэн, уран бүтээлчдийн шилжилт хөдөлгөөнийг дэлхий дахинд түгээн дэлгэрүүлэхэд хөнгөлөлтийн журмыг хэрэгжүүлнэ	Соёлыг тогтвортой хөгжлийн бодлого болон олон улсын тусламжийн хөтөлбөрийн стратегийн цар хүрээтэй уялдуулна	Хүний үндсэн эрх, эрх чөлөөтэй холбоотой олон улсын болон үндэсний хууль тогтоомжийг хэрэгжүүлж бүтээн туурвих эрх чөлөө болон уран бүтээлчдийн нийгэм, эдийн засгийн эрхийг хөхиүлэн дэмжинэ

Соёлын мэргэжилтэн, уран бүтээлчдийн шилжилт хөдөлгөөн	***Соёлын бүтээг-дэхүүн, үйлчилгээ-ний урсгал***	***Гэрээ ба хэлэлцээр***	***Тогтвортой хөгжлийн үндэсний бодлого, төлөвлөгөө***	***Тогтвортой хөгжлийн олон улсын хөтөлбөрүүд***	***Жендэрийн тэгш байдал***	***Уран бүтээлийн эрх чөлөө***
Шилжилт хөдөлгөөний эрх чөлөөг хууль тогтоомжоор баталгаажуулна	Соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний урсгалыг хууль тогтоомжоор дэмжинэ	Талууд конвенцийн зорилго, зарчмуудыг өөр хэлбэрээр хөхиүлэн дэмжинэ	Соёлыг тогтвортой хөгжлийн үндэсний бодлого, төлөвлөгөөтэй нэгтгэнэ	Соёл нь олон улсын тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсэг болдог Соёлыг тогтвортой хөгжлийн олон улсын хөтөлбөртэй уялдуулна	Соёлын талбар дахь жендэрийн тэгш байдлыг хууль тогтоомжоор баталгаажуулна	Илэрхийлэх эрх чөлөөг хууль тогтоомжоор дэмжинэ
Өмнөдийн шилжилт хөдөлгөөнийг бодлого, арга хэмжээгээр дэмжинэ	Соёлын бүтээгдэ-хүүний олон улсын урсгалыг бодлого, арга хэмжээгээр дэмжинэ	Олон улсын болон бүс нутгийн гэрээ, хэлэлцээрт конвенцийн заалтуудыг тодорхой тусгана	Соёлын нөөцийг хуваарилахад бүс нутгийн тэгш байдлыг баримтлахыг бодлого, арга хэмжээгээр дэмжинэ	Хөгжиж буй орнуудын соёлын болон бүтээлч үйлдвэрлэлийн хүний нөөц, институцийн чадавхийг техникийн туслалцааны хөтөлбөрөөр дамжуулан бэхжүүлнэ	Эмэгтэйчүүдийг соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээг бүтээгч, үйлдвэрлэгч хэмээн үзэж бодлого, арга хэмжээгээр дэмжинэ	Уран бүтээлийн эрх чөлөөг бодлого, арга хэмжээгээр хамгаалж хөхиүлэн дэмжинэ
Өмнөдийн шилжилт хөдөлгөөнийг төрийн бус байгууллагын санаачлагаар дэмжинэ	Соёлын үйлчилгээний олон улсын урсгалыг бодлого, арга хэмжээгээр дэмжинэ	Олон улсын болон бүс нутгийн гэрээ, хэлэлцээрийг конвенцтэй уялдуулахыг бодлого, арга хэмжээгээр хэрэгжүүлнэ	Эмзэг бүлгийн соёлын нөөцийг тэгш хүртэх эрхийг бодлого, арга хэмжээгээр хангана	Хөгжиж буй орнуудын бүтээлч байдлыг санхүүгийн туслалцаагаар дэмжинэ	Эмэгтэйчүүдийн соёлын үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээ хүртэх боломжийг бодлого, арга хэмжээгээр нэмэгдүүлнэ	Уран бүтээлчдийн нийгэм, эдийн засгийн эрхийг бодлого, арга хэмжээгээр хангана

Зорилго 1

Соёлын засаглалын тогтвортой тогтолцоог дэмжинэ

Ил тод, мэдээлжсэн, оролцооны үйл явц бүхий засаглалын тогтолцоонд тулгуурлан соёлын илэрхийллийн олон төрлийг хөхиүлэн дэмжих бодлогыг баталж хэрэгжүүлэх улсуудын хараат бус бүрэн эрх баталгаажсан байна.

2018 ТАЙЛАНГИЙН БҮДҮҮВЧ

Соёлын олон төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг бүтээх, үйлдвэрлэх, түгээх, хүртэх эрхийг хөхиүлэн дэмжиж ил тод, мэдээлжсэн, оролцооны тогтолцоо бүхий соёлын засаглалд хувь нэмэр оруулахад чиглэсэн үндэсний бодлого, арга хэмжээг хэрэгжүүлнэ

Соёлын бодлогууд	*Олон нийтийн хэвлэл мэдээлэл*	*Цахим орчин*	*Иргэний нийгэмтэй түншлэх*

ОЛОЛТ АМЖИЛТУУД

- Соёлын үйлдвэрлэл, интернэт хандалт, хэвлэл мэдээллийн эрх чөлөө, олон янз байдлыг дэмжсэн хууль эрх зүйн үндэслэлийг бий болгосон
- Салбарын яамд хоорондын бүтээлч эдийн засгийн хамтын ажиллагаа өргөжсөн
- Цахим бүтээлч байдал, аж үйлдвэрлэлд оруулах хөрөнгө оруулалт нэмэгдэж байна
- Соёлын бодлогын асуудалд иргэний нийгмийн байгууллагууд оролцож байна

СОРИЛТ БЭРХШЭЭЛҮҮД

- Соёлын бодлогыг бүрэн хэрэгжүүлэхэд хангалттай төсөв үгүй
- Иргэний нийгмийн байгууллагууд бодлогын үйл явцад бүрэн дүүрэн нөлөөлөх чадамж сул
- Олон нийтийн хэвлэл мэдээллийн бодлого нийгмийн бүх бүлгүүдэд хүрч үйлчлэхгүй
- Цахим орчинд бүтээл туурвигчдийн урамшуулал шударга бус

ЗӨВЛӨМЖҮҮД

- Бодлогын хэлэлцүүлэг хийх бүтцийн платформыг хөгжүүлэх
- Иж бүрэн цахим хөтөлбөр, дэд бүтцийн төлөвлөгөө батлах
- Иргэний нийгмийн байгууллагуудын хангалттай нөөц бүрдүүлэх, ур чадварыг нэмэгдүүлэх
- Орон нутагт чанартай контент үйлдвэрлэхэд хөрөнгө оруулах

ХЭРЭГЦЭЭТ МЭДЭЭЛЭЛ

- Уран бүтээлчид ба цахим түгээлтийн платформоос бий болгосон орлого
- Олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагад хаалгачийн үүрэг гүйцэтгэж буй эмэгтэйчүүдийн тоо
- Соёлын бодлого боловсруулах үйл явцад оролцож буй иргэний нийгмийн байгууллагуудын тоо

ОЛОН ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫГ ХАМРУУЛСАН БОДЛОГО БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ ЯВЦ БҮХИЙ ХАМТЫН ЗАСАГЛАЛААР СОЁЛЫГ БЭХЖҮҮЛНЭ



НЭГДСЭН БОДЛОГОД ЧИГЛЭХ

Бүтээх
Урлагийн сургуулиуд оюутнуудад бүтээлч ур чадварыг олгодог

Үйлдвэрлэх
Санхүүгийн шууд хөрөнгө оруулалтаар дотоодын соёлын контент үйлдвэрлэлийг нэмэгдүүлдэг

Түгээх
Соёлын илэрхийллийг түгээх асуудлыг соёлын дэд бүтцээр дэмждэг

Хүртэх
Үнэ өртөг, зай, хэл гэх мэт сорилт бэрхшээлүүдийг оролцооны стратегийн хүчээр даван туулдаг

СОЁЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХӨГЖИЛ ХӨДӨЛГӨӨНИЙГ ДЭМЖДЭГ

үнэ цэн
$2,250 тэрбумын

дэлхийд
30 сая
хүн ажиллаж байна

Design: infographic.ly

Бүлэг 1

Хамтын ажиллагаа давамгайлсан соёлын засаглалд шилжих нь

Жорди Балта Портолес

ГОЛ САНААНУУД

- ***Соёлын бодлого, хууль тогтоомжийг танилцуулж өөрчлөгдөн буй цаг үедээ тохируулах хүсэл эрмэлзэл, зүй тогтлыг конвенцийн хүрээнд хангана.***
- ***Олон талт оролцогч талуудтай бодлого боловсруулах үйл явц болон хамтын засаглалд, нэн ялангуяа хөгжиж буй зарим орнуудад, бүтээлч эдийн засаг, соёлын боловсролын салбарт нөлөө үзүүлэх эхлэл нь конвенцийн хэрэгжилт юм.***
- ***Боловсрол, худалдаа, эдийн засгийн хөгжлийн талбарт конвенцийг хэрэгжүүлэх чадамж заримдаа хязгаарлагдмал байдаг хэдий ч орон нутаг, бүс нутгийн удирдлагууд соёлын бодлогын тодорхой санаачлагуудыг хэрэгжүүлж байна.***
- ***Соёлын бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээний хүрээнд санхүүгийн шууд хөрөнгө оруулалттайгаар явуулж буй бодлогыг батлаж хэрэгжүүлэх болон үзэгчдийн орон нутагт үйлдвэрлэсэн контентыг үзэх боломжийн хооронд харилцан хамаарал бий бөгөөд энэ нь хөгжиж буй орнуудад гол төлөв ажиглагддаг.***
- ***Үр дүнд үнэлгээ, дүн шинжилгээ хийх явдал цөөн байгаагаас мэдээллийн хүртээмж хангалтгүй болж улмаар соёлын илэрхийллийн олон төрлийг дэмжихэд соёлын бодлогын үр нөлөөтэй эсэхэд үнэлгээ хийхэд хүндрэл учирч байна.***

Шинэ улсыг байгуулахад соёл чухал үүрэгтэй. Өөрийн гарал үүслээ мэддэг, уншиж чаддаг хамт олонд уран бүтээлчдийг дэмждэг соёлын орон зай байдаг бөгөөд өөрийн соёлын олон төрлөөр бахархаж энх тайвныг цогцлоох арга хэрэгсэлтэй нийгмийг бүрдүүлдэг.

Мариана Гарсес Кордова

Колумбын Соёлын сайд

ЭРИН ҮЕД

Хэвлэл мэдээллийн нийлүүлэлт

Хэвлэл мэдээллийн бөөгнөрөл

Хэвлэлийн мэдээллийн сүлжээ

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ, ОЛОН ТӨРӨЛ НЬ ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ БЭХЖҮҮЛЖ ХООРОНДЫН ТЭНЦВЭРИЙГ ХАДГАЛАХ БОДЛОГЫГ ШААРДДАГ.

орон нутгийн контент **ба** бүс нутаг, олон улсын контент

ТИЙМЭЭС 90 УЛС ОРОНД КВОТЫН ЗАРЧМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭЭД БАЙНА.

Жилд дундажаар олон нийтийн телевизийн үнэ төлбөргүй нэвтрүүлгийн **25.8%** дотоодынх байдаг.

54 Улс орон өөрийн үндэсний контентэд тодорхой квот тогтоон ажиллаж байна.

МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙГ

2016 онд дэлхий дахинд хэвлэлийн эрх чөлөөний **115** хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Гэхдээ хэвлэл мэдээллийн эрх чөлөөний төлөв байдал улс орнуудын **66%**-д нь буурсан үзүүлэлттэй байна.

ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН НЭГЭН АДИЛ МӨРДӨХ ХЭРЭГТЭЙ.

ЗӨВХӨН

19% ТӨРИЙН МЭДЛИЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГУУДАД ЗОРИУЛСАН ЖЕНДЭРИЙН ОЙЛГОЛТЫН ТУСГАЙ ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН БАЙНА.

СОЁЛЫН ИЛЭРХИЙЛЛИЙН ОЛОН ТӨРЛИЙГ ТӨРИЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛД БҮРЭН ТУСГАХЫН ТУЛД ДАРААХ ХҮЧИН ЧАРМАЙЛТЫГ ГАРГАХ ШААРДЛАГАТАЙ. ҮҮНД:

- чанартай контент бий болгохыг дэмжих
- хамтарсан бүтээлийн хөтөлбөр хөгжүүлэх
- чадавхжуулалт болон техникийн туслалцааг нэмэгдүүлэх
- санхүүгийн хөшүүрэг, зөвшөөрлийг хялбаршуулах ажлыг дэмжих

Design: infographic.ly

Бүлэг 2

Сонголтыг өргөжүүлэх: Соёлын контент ба олон нийтийн хэвлэл мэдээлэл

Кристин М.Меркэл

ГОЛ САНААНУУД

- ***Телевиз үзэж радио сонсох нь дэлхийн дийлэнх хүмүүсийн хувьд соёлын үйл ажиллагааны гол хэлбэр болдог бол хэвлэл мэдээллийн өндөр чанартай контентын олон төрлийг дэмжих бодлого нь конвенцийн зорилготой маш их уялдаатай.***
- ***Засгийн газрууд олон нийтийн хэвлэл мэдээллийн бодлого, тогтолцоогоо шинэчилдэг учраас хэвлэл мэдээллийн эрх чөлөө, олон талт байдлын асуудлаар хууль эрх зүйн зохицуулалтын хүрээнд бодит сайжруулалт олон гарсан.***
- ***Олон нийтийн болон хувийн хэвлэл мэдээллийн бүтээлч болон олон талт байдлыг одоогоор дэлхий дахинд 90 улс оронд хэрэгжиж буй квотын зарчмаар хангаж байна.***
- ***Цахим орчинд тохируулсан бодлогын шинэ цар хүрээ нь хэвлэл мэдээллийн босоо болон хэвтээ нийлүүлэлтийн сорилт бэрхшээлд нөлөө үзүүлэх эхлэл болж байна.***
- ***Бүх хувь хүн, бүлгийн хэрэгцээ шаардлага болон олон нийтийн сэтгэлгээний өөрчлөлт, түүнчлэн нийлүүлэлтийн үйл явцад тохирсон, цаашид хөгжих боломжтой олон нийтийн хэвлэл мэдээллийн загвар бодлогыг хэрэгжүүлэх хэрэгтэй.***

> *Хамтын контент гэдэг бол чухал зүйл. Үзэгчидтэй түншлэх нь нэвтрүүлэгчдийг амжилтад хүргэж олон нийтийн итгэлийг нэмэгдүүлдэг. Энэ нь зөвхөн бидний бий болгосон контент байгаад зогсохгүй цаашид биднийг урагшлуулан хөгжүүлэх арга зам юм.*
>
> ***Жавад Моттахи***
>
> *Ази, Номхон далайн Өргөн нэвтрүүлгийн холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга*

ЦАХИМ ТЕХНОЛОГИУД БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НЭМҮҮ ӨРТГИЙН СҮЛЖЭЭГ ХУВИРГАН ӨӨРЧИЛСНӨӨР



Дамжуулах загвар **Сүлжээний загвар**

СОЁЛЫН ЭДИЙН ЗАСАГ НЭЛЭЭД ЦАХИМЖСАН



*хөгжмийн үйлдвэрийн орлогууд нь цахим борлуулалт байв.

ГЭВЧ ТОМ ПЛАТФОРМ БИЙ БОЛСОН ЯВДАЛ НЬ ОЛОН СОРИЛТ БЭРХШЭЭЛИЙГ ДАГУУЛСАН

ЭДГЭЭР СОРИЛТ БЭРХШЭЭЛҮҮДИЙГ ДАВАН ТУУЛАХЫН ТУЛД УЛС ОРНУУД ДАРААХ ЗҮЙЛИЙГ ХИЙХ ЁСТОЙ. ҮҮНД:

- орон нутгийн соёлын үйлдвэрлэлд хөрөнгө оруулахад чиглэсэн цахим стратеги,
- бүтээлч хуб, инкубатор, кластерийг дэмжих
- олон янзын цахим контентэд нэвтрэх боломжоор хангахын тулд цахим бичиг
- хамтын шинэ түншлэлийг хөгжүүлэх

Design: infographic.ly

Бүлэг 3

Платформын эрин үе дэх соёлын бодлого

Октавио Кулец

ГОЛ САНААНУУД

- ***Соёлын бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээ нь дамжуулалтын хэлбэрээс сүлжээний загварт хурдацтайгаар хувьсан шилжиж байна. Эдгээр өөрчлөлтүүдтэй тэмцэх стратеги цөөн хэдэн оронд л хэрэгжиж байна.***
- ***Маш цөөн оролцогч талууд нэмүү өртгийн сүлжээний тодорхой зангилааг цахимжуулах буюу хөгжүүлэх санаачлагуудыг хэрэгжүүлэхээс гадна цахим соёлын бодлогыг боловсруулж хэрэгжүүлж байна.***
- ***Өмнөдөд үүрэн утасны сүлжээний үй олон хэрэглээнээс үүдэлтэй давуу тал байгаа хэдий ч олон улс оронд дэд бүтэц сул, цахим орчинд соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлийг бэхжүүлэх боломж хомс байна.***
- ***Интернэт орчин дахь мэдээллийн цар хэмжээ тэлэхийн сацуу орлого ч бас нэмэгдэж байна. Хөгжмийн зах зээл дэх цахим орлого 2016 онд 17.7%-иар өсөж эргэлтийн орлогод 60.4%-ийн онцгой өсөлтийг бий болгосон. Энэ нь анх удаа цахим орлого дуу бичлэгийн хөгжмийн зах зээлийн 50%-д хүрсэн явдал юм.***
- ***Том платформуудын өсөлт, зах зээлийн төвлөрөл, эсхүл хиймэл оюун ухааны монопольд чиглэсэн зорилтот аргыг батлахгүй бол улсын салбар бүтээлч талбар дахь агентлагаа бүхэлд нь алдаж болно.***
- ***Бодлогын хүрээний хамтын ажиллагаа, бүтээн байгуулалт, үйл ажиллагааны солилцоонд тулгуурласан төр, хувийн хэвшил, иргэний нийгэм хоорондын харилцааны шинэ хэлбэр хараахан бий болоогүй байна***

Олон нийтийг эрх мэдэлжүүлэх, оролцооны шинэ загварыг өргөтгөх, урлаг, загвар, програм хангамж, шинжлэх ухаан, технологийн солбилцлыг дэмжих үйл явцыг ойлгох шинэ аргыг цахим сүлжээ, хамтын платформаар бий болгосон.

Филип Цезарь Лондоно

Имажин олон улсын фестивалийн захирал

Соёлын засаглалын ил тод, мэдээлжсэн, оролцоо бүхий тогтолцоонд хувь нэмэр оруулах үндэсний бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэхэд

- ил тод
- мэдээлэлтэй
- оролцоо

иргэний нийгмийн хүчтэй оролцоо чухал байдаг.

Иргэний нийгмийн байгууллагуудын хүчтэй цөм нь илүү албан бодлогын орон зайгаар дамжуулан соёлын бодлогыг сайжруулсаар байна.

Иргэний нийгмийн байгууллагуудын **63%** нь үндэсний соёлын бодлого, эсхүл зөвлөлдөх механизмд хувь нэмэр оруулсан.

Иргэний нийгмийн байгууллагуудын **70%** нь өөрсдийгөө бодлогын орчинд өөрчлөлт хийж чаддаг гэж үздэг.

ГЭВЧ ҮҮНД ХЭД ХЭДЭН БЭРХШЭЭЛ БИЙ

Тэдний оролцоог одоо мөрдөгдөж буй хууль тогтоомжуудын хүрээнд бүрэн дүүрэн хангаж чадахгүй байна.

30% Иргэний нийгмийн байгууллагуудын нь тэднийг төрийн байгууллагуудтай түншлэх боломжийг хууль тогтоомжийн хүрээнд хангаагүй гэдэгт итгэдэг.

Төр засгийн зөвлөлдөх механизмын бүтэц нь нээлттэй, тохиромжтой, эсхүл холч бодлоготой биш байна.

40% Иргэний нийгмийн байгууллагуудын нь соёлын бодлого боловсруулалт ил тод биш гэдэгт итгэдэг.

Нөөц, чадамж, сүлжээ зэрэг нь сул байна

23% нь иргэний нийгмийн бусад байгууллагуудтай тогтмол хамтран ажилладаггүй.

СОЁЛЫН ЗАСАГЛАЛЫН ИЛҮҮ САЙН ТОГТОЛЦООГ БИЙ БОЛГОХЫН ТУЛД ИЛҮҮ ИХ ХҮЧИН ЧАРМАЙЛТ ГАРГАХ ШААРДЛАГАТАЙ. ҮҮНД:

- байнгын, тасралтгүй үргэлжлэх, зохион байгуулалт бүхий оролцооны үйл явцыг хөгжүүлэх
- ИНБ-уудын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх
- чадавхийг хөгжүүлж бэхжүүлэх
- соёлын болон соёлын бус ИНБ-уудын салбар хоорондын түншлэлийг дэмжих

Design: infographic.ly

Бүлэг 4

Соёлын засаглалд иргэний нийгмийг оролцуулах нь

Андрью Фирмин

ГОЛ САНААНУУД

- ***Соёлын засаглалын тогтвортой тогтолцоог дэмжих тухай конвенцийн зорилгыг зөвхөн иргэний нийгмийн хүчтэй оролцоотойгоор хангаж чадна.***
- ***Бодлого боловсруулах үйл явц ил тод биш бөгөөд иргэний нийгмийн оролцоог хууль тогтоомжийн хүрээнд хангахгүй байна гэдэгт иргэний нийгмийн олонх итгэдэг.***
- ***Соёлын засаглалыг сайжруулах болон соёлын бодлогыг хөгжүүлэхэд иргэний нийгмийн хүчтэй цөм гол үүрэг гүйцэтгэнэ.***
- ***Иргэний нийгмийн оролцогчид өөрсдийн найз нөхдийгөө мэдлэг бүтээх, хуваалцах, сурталчлах, шинэ сүлжээг бий болгох зэрэгт татан оролцуулан конвенцид дэмжлэг үзүүлдэг.***
- ***Илүү их амжилтад хүрэхийн тулд иргэний нийгмийн цөм нь бодлогын оролцоо, харилцаа холбоо, сүлжээнд анхаарч хүний нөөц, чадавхийг бэхжүүлэх шаардлагатай.***

> *Төрийн байгууллагуудтай хүчин чармайлтаа нэгтгэж соёл ба залуучуудад хөрөнгө оруулалт хийх замаар Африкт шинэ засаглалыг бий болгосон чанарын эрс өөрчлөлт нь нийгмийн нягтрал, бүтээлч эдийн засгийг бэхжүүлж, иргэдийг сайн сайхан амьдрахад хувь нэмэр оруулахуйц бодит ажил хэрэг болж байна.*
>
> ***Мамоу Даффе***
>
> *Артерийн сүлжээний дарга*

Зорилго 2

СОЁЛЫН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЭНЦВЭРТ УРСГАЛЫГ ХАНГАХ, СОЁЛЫН МЭРГЭЖИЛТЭН, УРАН БҮТЭЭЛЧДИЙН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

Соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний урсгалын тэгш хүртээмж, нээлттэй, тэнцвэрт байдал болон соёлын мэргэжилтэн, уран бүтээлчдийн чөлөөт шилжилт хөдөлгөөнийг хөхиүлэн дэмжинэ.

2018 ТАЙЛАНГИЙН БҮДҮҮВЧ

Соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний тэнцвэрт урсгалыг хадгалж дэлхий дахинд соёлын мэргэжилтэн, уран бүтээлчдийн шилжилт хөдөлгөөнийг дэмжихийн тулд хөнгөлөлтийн арга хэрэгслийг авч хэрэгжүүлнэ.

Соёлын мэргэжилтэн, уран бүтээлчдийн шилжилт хөдөлгөөн	*Соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний урсгал*	*Гэрээ хэлэлцээрүүд*

ОЛОЛТ АМЖИЛТУУД

- Өмнөдөд үндэстэн дамнасан хамтын ажиллагаа, шилжилт хөдөлгөөн нэмэгдсэн
- Өмнөдөд цахим платформ болон сүлжээний тоо нэмэгдэж дуу, дүрс бичлэгийн зах зээлийг нээлттэй болгох стратегийг экспортлох явдал өссөн
- Соёлын асуудлыг хоёр талын болон бүс нутгийн худалдааны гэрээ хэлцлийн заалтуудад өргөнөөр тусгах болсон

СОРИЛТ БЭРХШЭЭЛҮҮД

- Дэлхийн өнөөгийн аюулгүй байдал дахь хөдөлгөөний хоригууд
- Соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний дэлхий нийтийн урсгал дахь байнгын тэнцвэрт бус байдал
- Бүс нутгийн түншлэлийн томоохон гэрээ хэлцэлд 2005 оны конвенцийн үүрэг оролцоо хязгаарлагдмал

ЗӨВЛӨМЖҮҮД

- Уран бүтээлчдийн визийн нөхцөлийг сайжруулах
- Худалдааны тусламж болон хөнгөлөлтийн арга хэрэгслийг хэрэгжүүлэх
- Цахим худалдаа үйлчилгээнд чиглэсэн худалдааны хэлэлцээрт соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний тусгай статусыг олгох

ХЭРЭГЦЭЭТ МЭДЭЭЛЭЛ

- Соёлын үйлчилгээний худалдаа
- Шилжилт хөдөлгөөний урсгал

УРАН БҮТЭЭЛЧДИЙН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНД ДАРААХ ЗҮЙЛС ХҮНДРЭЛ УЧРУУЛЖ БАЙНА. ҮҮНД:

- олон улсын аюулгүй байдлын арга хэрэгсэл
- визийн оновчтой бус журам, өргөдлийн хураамж өндөр
- хууль тогтоомжоор хүлээн зөвшөөрсөн ажил хангалтгүй
- санхүүжилт, дэмжлэг бага

ӨМНӨД-ӨМНӨДИЙН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН, ХАМТЫН АЖИЛЛАГААНД ӨСӨЛТ БИЙ БОЛСОН.



Өмнөдийн паспорт эзэмшигчдэд визийн хөнгөлөлт үзүүлэх орнуудын тоо нэмэгдсэн.

2015 онд **70** 2015 онд улс орон байсан бол → 2017 онд **75** улс орон болсон

Гэхдээ эдгээр тоо нь Өрнөдийн паспорт эзэмшигчдээс бага байна.

2017 онд **156** улс байна

Өмнөдийн уран бүтээлчид Умардын шилжилт хөдөлгөөний санхүүжилтийн зөвхөн **18%** %-ийг хүртэх боломжтой.

ИЙМ ЯЛГААТАЙ БАЙДЛЫГ НЭГДСЭН ЗОХИЦУУЛАЛТЫН ДАРААХ АРГААР ЗӨВХӨН АРИЛГАНА.

- хөнгөлөлтийн арга хэрэгслийг нэвтрүүлэх
- визийн журмыг хөнгөвчилж хураамжийг багасгах
- зохих дэд бүтэц, хөрөнгө оруулалт, мэдээллээр хангах
- чадавхийг бэхжүүлэхээс гадна Өмнөд-Өмнөдийн сүлжээний боломжийг нэмэгдүүлэх

Design: infographic.ly

Бүлэг 5

Шилжилт хөдөлгөөний логик зөрчлийг арилгах

Хадижа Эл Бэннаоу

ГОЛ САНААНУУД

- ***Өмнөдийн соёлын ажилтан, уран бүтээлчдийн хүрэх гол зах зээлийг Умард хангаж байгаа бол эдгээр зах зээлд хүрэх боломж бололцоо дэлхий нийтийн өнөөгийн аюулгүй байдлаас үүдэн нэлээд төвөгтэй болж байна.***
- ***Умард, Өмнөд хоорондын байнгын тэгш бус байдалд анхаарал хандуулсан иргэний нийгэм болон соёлын байгууллагуудын хүчин чармайлтыг визийн нөхцөлүүд талаар болгож байна.***
- ***Уран бүтээлчдийн шилжилт хөдөлгөөн, хөдөлгөөний эрх чөлөөний хязгаарлалтыг цэнзур тавих, хааж боогдуулах арга хэрэгсэл болгон ашиглаж байна.***
- ***Зах зээлд нэвтрэх замаар хэрэгжүүлж буй шилжилт хөдөлгөөний боломжит тоо хэмжээ, үндэстэн дамнасан соёлын хамтын ажиллагаа нь Өмнөд-Өмнөдийн шилжилт хөдөлгөөний шинэчилсэн ашиг сонирхлын хамт өсөн нэмэгдэж байна.***
- ***Институцийн цар хүрээ, санхүүжилтын бүтэц хэдийгээр хангалтгүй байгаа ч Өмнөдөд бүс нутгийн шинэ сүлжээ, солилцооны платформ, бүтээлч хаб бий болсон. Эдгээр нь урлагийн салбарын олон янз, хараат бус байдлын ачаар бий болсонд талархах нь зүйтэй.***

ЮНЕСКО-ийн 2005 оны конвенц нь илүү их сорилт бэрхшээлтэй тулгарч буй Өмнөдийн бүхий л уран бүтээлчдэд итгэл найдвар төрүүлдэг.
Засгийн газрууд шилжилт хөдөлгөөнийг дэмжих, хамтын бүтээл гаргах, уран бүтээлчдэд хөнгөлөлтийн арга хэрэгслийг ашиглах боломжийг олгодог.
Ийм мэдээллийг хаана ч гэсэн хүчтэйгээр түгээх ёстой.

Абдеррахмани Сисако

Кино найруулагч

Гэвч **соёлын бүтээгдэхүүний дэлхийн экспортын хувь хэмжээ** тэнцвэртэй бус байна

26.5%
Хөгжиж буй орнууд (Хятад, Энэтхэгийг оруулахгүйгээр)

0.5%
Хөгжил буурай орнууд

Түүнчлэн төрөл зүйл ч хангалттай бус байна

Хөгжиж буй орнууд:

23.3%
Хөгжмийн бүтээгдэхүүн

32%
Харааны урлагийн бүтээгдэхүүн

18.3%
Хэвлэмэл бүтээгдэхүүн

ИЛҮҮ ТЭНЦВЭРТ УРСГАЛД ХҮРЭХИЙН ТУЛД ҮҮНИЙГ ХИЙХ ШААРДЛАГАТАЙ.

- худалдааны чадавх, дэд бүтцийг баталгаажуулах
- худалдаатай холбоотой хөтөлбөр, төслүүдэд чиглэсэн хөгжлийн албан ёсны тусламж (ODA)-ийг нэмэгдүүлэх
- соёлын бүтээгдэхүүний экспортыг төрөлжүүлэхийн тулд бүтээлч салбарт хөрөнгө оруулалт хийх
- соёлын бүтээгдэхүүнийг шинэ зах зээлд хямд үнээр нэвтрэх боломжийг дэмжсэн хөнгөлөлттэй тариф
- цахим орчин дахь соёлын худалдаа үйлчилгээний мэдээллийн сан бүрдүүлэлтийг сайжруулах

Design: infographic.ly

Бүлэг 6

Соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний урсгалын тэнцвэрт бус байдалтай тэмцэх нь

Лидиа Делоумиау

ГОЛ САНААНУУД

- ***Хөгжиж буй бүх улс орнуудын (Хятад, Энэтхэгийг оролцуулан) дэлхийн соёлын бүтээгдэхүүний урсгалд эзлэж буй хувь нь өсөн нэмэгдсээр байгаа бөгөөд 2005 онд дэлхийн соёлын бүтээгдэхүүний худалдааны 25%-ийг бүрдүүлж байсан бол 2014 онд 45% болж нэмэгдсэн байна.***
- ***Худалдааны хориг саад, хөнгөлөлтийн арга хэрэгслийн дутмаг байдал, хүний нөөц, санхүүгийн чадавхийн хязгаарлагдмал байдал зэрэг нь хөгжиж буй орнуудыг Умардын соёлын бүтээгдэхүүний зах зээлд нэвтрэхэд хүндрэл учруулсаар байна.***
- ***Цахим түгээлтийн платформ, солилцооны сүлжээ, экспортын стратеги зэрэг нь Өмнөдийн орнуудыг соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний олон улсын зах зээлд, ялангуяа дуу, дүрс бичлэгийн салбарт нэвтрэхэд дэмжлэг болж байна.***
- ***Дотооддоо квот тогтоох нь дуу, дүрс бичлэгийн үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх үр дүнтэй арга төдийгүй улмаар экспортыг нэмэгдүүлэхэд чиглэдэг.***
- ***Нотолгоонд суурилсан бодлого, худалдааны хэлэлцээрийг дэмжихийн тулд соёлын худалдаа үйлчилгээний мэдээлэл бүрдүүлэлтийг яаралтай сайжруулахыг шинэ цахим орчин шаардаж байна.***

> *Залуу кино найруулагчдыг илүү чөлөөтэй, олон төрлийн кино үйлдвэрлэхийг дэмжсэн хамтын бүтээлийн хэлэлцээрийн ач холбогдлыг дурдахгүй өнгөрч болохгүй.*
>
> ***Наоми Кавазе***
>
> *Кино найруулагч*



Design: infographic.ly

Бүлэг 7

Конвенц олон улсын бусад форумд: онцгой үүрэг амлалт

Вероник Гувремонт

ГОЛ САНААНУУД

- ***2015-2017 оны хооронд байгуулсан бүс нутгийн болон хоёр талын чөлөөт худалдааны 8 гэрээ хэлцэлд 2005 оны конвенцийн зорилго, зарчмуудыг хөхиүлэн дэмжих соёлын заалтууд, эсхүл үүрэг амлалтын жагсаалтыг тусгасан.***
- ***Бүс нутгийн түншлэлийн томоохон гэрээ хэлэлцээрүүдэд 2005 оны конвенцийн зорилго, зарчмуудыг хөхиүлэн дэмжих орон зай бага байсан хэдий ч Номхон далайн түншлэл(TTP)-ийн зарим талууд соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих талаар соёлын чухал нөхцөлүүдийг тусгахад амжилт олсон.***
- ***Хэдийгээр 2015-2017 онд соёлын хамтын ажиллагааны шинэ протоколд гарын үсэг зурагдаагүй ч чөлөөт худалдааны бусад гэрээнд өргөн нэвтрүүлгийн болон дуу, дүрс бичлэгийн салбарт хөнгөлөлтийн журам үйлчлэх заалтуудыг тусгасан.***
- ***Европын холбоо болон бүс нутгийн бусад байгууллагууд соёлын болон соёлын бүтээлч үйлдвэрлэлийн бодлого, стратегиа төлөвлөхдөө 2005 оны конвенцийн зарчмуудтай нийцүүлэхэд чиглэсэн шийдвэрлэх алхмуудыг авч хэрэгжүүлсэн. Нэн ялангуяа дуу, дүрс бичлэгийн салбарт цахим шинэ орчны сорилт бэрхшээлүүдийг авч үзсэн.***

> *Соёлын олон төрлийг хөхиүлэн дэмжих нь ялгаварлан гадуурхал, хэлний бэрхшээлтэй тэмцэх хамгийн оновчтой арга бөгөөд олон нийттэй хамтдаа байх боломжийг бүрдүүлдэг.*
>
> ***Тивор Наврасикс***
>
> *Европын боловсрол, соёл, залуучууд, спортын асуудал эрхэлсэн комиссар*

Зорилго 3

СОЁЛЫГ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХҮРЭЭТЭЙ УЯЛДУУЛАХ НЬ

Тогтвортой хөгжлийн эдийн засаг, соёлын талын сонголтыг хүлээн зөвшөөрнө.

2018 ТАЙЛАНГИЙН БҮДҮҮВЧ

Соёлыг тогтвортой хөгжлийн бодлого болон олон улсын тусламжийн хөтөлбөрүүдэд стратегийн хүрээнд нэгтгэнэ.

Тогтвортой хөгжлийн үндэсний бодлого, төлөвлөгөө	*Тогтвортой хөгжлийн олон улсын хөтөлбөрүүд*

ОЛОЛТ АМЖИЛТУУД

- Тогтвортой хөгжлийн 2030 зорилтуудад бүтээлч байдлын үүрэг оролцоог тусгасан
- Өмнөдөд соёлын асуудлыг үндэсний хөгжлийн стратеги, төлөвлөгөөтэй нягт уялдуулсан
- Соёлын олон төрлийг дэмжих олон улсын санд Өмнөдийн оруулах хувь нэмэгдсэн
- Хотууд соёлын үйлдвэрлэлийн хөгжилд оруулах хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлсэн

СОРИЛТ БЭРХШЭЭЛҮҮД

- Соёлд зарцуулах албан ёсны хөгжлийн туслалцааны хэмжээ сүүлийн 10 жилд хамгийн бага байна
- Хөгжлийн дийлэнх төлөвлөгөөнд бүтээлч байдлын үр дүнг тодорхой тусгаагүй байна
- Соёлын нөөцийн хүртээмж тэгш бус хуваарилагдаж байна
- Соёлын бүтээгдэхүүн, уран бүтээлийн практикт байгаль орчны нөлөөллийг ойшоохгүй байна.

ЗӨВЛӨМЖҮҮД

- ТХЗ-уудыг хэрэгжүүлэхэд соёлын сайд нарыг оролцуулах
- Үндэсний хөгжлийн төлөвлөгөөнд бүтээлч байдлыг нэтгэхэд төсөв хуваарилах
- Соёлын олон төрлийг дэмжих олон улсын сан болон Хөгжлийн албан ёсны тусламжийн соёлд зарцуулах дэмжлэгийг нэмэгдүүлэх
- Өмнөдийн бүтээлч жижиг дунд үйлдвэрлэлийн сүлжээг дэмжих

ХЭРЭГЦЭЭТ МЭДЭЭЛЭЛ

- Өмнөдийн соёлын болон бүтээлч үйлдвэрлэлийн эдийн засгийн нөлөө
- Хөгжлийн бодлого дахь иргэний нийгмийн оролцоо
- Үндэсний хөгжлийн төлөвлөгөөнд зориулах төсвийн зарцуулалт
- Өмнөдийн уран бүтээлийн санаачлагад оруулах хөрөнгө оруулалт

2005 ОНЫ КОНВЕНЦИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ ТХЗ-УУДЫГ БИЕЛҮҮЛЭХЭД ШУУД НӨЛӨӨЛНӨ

2005 ОНЫ КОНВЕНЦИЙН ОЛОН ОРОЛЦОГЧ ТАЛУУД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНДӨӨ СОЁЛЫН АСУУДЛЫГ ТУСГАСАН

Одоо хэрэгжүүлж буй үндэсний хөгжлийн **111** төлөвлөгөөний

86%-д нь соёлын заалтууд тусгагдсан

бөгөөд түүний **2/3** нь Өмнөдийнх юм.

ГЭХДЭЭ

2015 оны байдлаар нийт хөгжлийн албан ёсны тусламжийн **0.22%** нь соёлын салбарт ногдож байсан нь 2005 онтой харьцуулахад

45% 45%-иар буурч

Сүүлийн **10** сүүлийн 10 жилийн хувьд хамгийн бага үзүүлэлт болж байна.

2011

US$1,563,216

Соёлын олон төрлийг дэмжих олон улсын санд оруулж буй оролцогч талуудын нэмэр хандив бас тасралтгүй буурсан.

2016

US$833,304

БҮТЭЭЛЧ БАЙДАЛД ОРУУЛАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ ЭЕРЭГ ҮР ДҮНГ БИЙ БОЛГОДОГ. ТУХАЙЛБАЛ,

ажлын байр нэмэгдүүлэх

тэгш бус байдлыг багасгах

уран бүтээлийн шинэ санаачлагууд нэмэгдэх

тогтвортой үйлдвэрлэл, хэрэглээ

Design: infographic.ly

Бүлэг 8

Соёлыг тогтвортой хөгжилтэй уялдуулах нь

Аврил Жофф

ГОЛ САНААНУУД

- ***2005 оны конвенцийн хэрэгжилт нь тогтвортой хөгжил дэх, нэн ялангуяа Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр дэх соёлын үүрэг оролцоог улам сайн ойлгуулахад хувь нэмэр оруулсан.***
- ***Хэдийгээр олон улсын тогтвортой хөгжлийн хэд хэдэн хөтөлбөрт соёлыг оролцооны гол хэсэг хэмээн үзэж байгаа ч өнөөдөр соёл болон амралт зугаалгад зарцуулж буй хөгжлийн тусламжийн хэмжээ сүүлийн 10 жилд хамгийн бага байна.***
- ***Үндэсний хөгжлийн стратеги, эсхүл төлөвлөгөө баталсан оролцогч талуудын 86% хөгжлийн соёлын хүрээний заалтуудыг тусгасан. Эдгээрээс гуравны хоёроос илүүтэй нь Өмнөдийнх юм.***
- ***Эдгээр орнууд соёлыг эхний ээлжинд арга хэрэгсэл, эдийн засаг буюу нийгмийн үр дүнг хөдөлгөгч хүч гэж үзсэн бол үндэсний хөгжлийн төлөвлөгөөний баримт бичгийн зөвхөн 40% конвенцийн зорилгод нийцсэн үр дүн, үйл ажиллагааг агуулсан байна.***
- ***Соёлын бүтээгдэхүүн, уран бүтээлийн практикт байгаль орчны нөлөөллийг зөвлөлийн түвшинд хангалттай авч үзээгүй байна.***
- ***Дэлхийн бүх хотууд соёлын бүтээлч үйлдвэрлэлээр дамжуулан тогтвортой хөгжлийг дэмжих шинэ арга замыг эрэлхийлж байна.***

Бид Өмнөдөд соёлын засаглал байгуулахын тулд соёлын талбарт ажиллагсдын дуу хоолойг сонсох, тэднийг татан оролцуулах, бусад түнш болон соёлын салбарын идэвхтэй оролцоо бүхий олон улсын бусад донорууд оролцуулж тэднийг сонсох нь зүйтэй юм.

Реми Риоу

Францын хөгжлийн агентлагийн Ерөнхий захирал

Зорилго 4

ХҮНИЙ ҮНДСЭН ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ ДЭМЖИХ

Хүний үндсэн эрх, эрх чөлөө, мэдээлэл харилцаа холбоог соёлын илэрхийллийн олон төрлийг бий болгох, түгээн дэлгэрүүлэхэд анхдагч гэдэг утгаар нь баталгаажуулна.

2018 ТАЙЛАНГИЙН БҮДҮҮВЧ

Хүний үндсэн эрх, эрх чөлөөтэй холбоотой олон улсын болон үндэсний хууль тогтоомжийг хэрэгжүүлж уран бүтээлчдийн нийгэм, эдийн засгийн эрх, уран бүтээлийн эрх чөлөөг дэмжинэ.

Жендэрийн тэгш байдал	*Уран бүтээлийн эрх чөлөө*

ОЛОЛТ АМЖИЛТУУД

- Соёлын салбарт жендэрийн тэгш байдлыг хөхиүлэн дэмжихийн ач холбогдлыг ойлгуулсан
- Уран бүтээлчдийн, нэн ялангуяа Африкийн уран бүтээлчдийн нийгэм, эдийн засгийн эрхийг дэмжсэн олон арга хэмжээ авч хэрэгжүүлсэн
- Бүтээн туурвих эрх нь хязгаарлагдсан уран бүтээлчдийн аюулгүй байдлыг хангах хотуудын тоо нэмэгдсэн

СОРИЛТ БЭРХШЭЭЛҮҮД

- Шийдвэр гаргах албан тушаал болон гол дүр бүтээхэд эмэгтэйчүүдийн төлөөлөл бага байна
- Эмэгтэйчүүдийн хүртэх санхүүжилт бага, цалингийн бодит зөрүү оршсоор байна
- Уран бүтээлч, үзэгчдийн эсрэг үйлдэгдсэн зөрчил нэмэгдсэн
- Өсөн нэмэгдэж буй цахим хяналт, онлайн дамжуулалт зэрэг нь урлагийн эрх чөлөөг хязгаарлаж байна

ЗӨВЛӨМЖҮҮД

- Жендэрийн үзэл баримтлалыг соёлын бодлогод тусгах
- Бүтээлч салбарт эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах байр суурийг бэхжүүлэх
- Уран бүтээлийн эрх чөлөөг хязгаарласан байдлыг хянан шинжлэх тогтолцоог бүрдүүлэх
- Гүтгэсэн, доромжилсон, хараасан өнгө аястай хууль дүрмийг хүчингүй болгох

ХЭРЭГЦЭЭТ МЭДЭЭЛЭЛ

- соёлын ажил мэргэжил, үйлдвэрт ажиллаж буй эмэгтэйчүүд
- цалин хөлс, татвар хураамж, үнэ өртгийн хүйсээр зааглаасан мэдээлэл
- соёлын аж амьдралд эмэгтэйчүүдийн оролцоо
- уран бүтээлийн эрх чөлөөг хязгаарласан байдал

ЖЕНДЭРИЙН ЯЛГААТАЙ БАЙДАЛ СОЁЛЫН САЛБАРТ ОРШИЖ БАЙНА.

Эмэгтэйчүүд

Гол дүр бүтээхэд эмэгтэйчүүдийн төлөөлөл бага байна.

Европт эмэгтэйчүүдийн найруулсан кино

1 2 3 4 5

Биллбордын 2017 оны 100 жагсаалтад

15 эмэгтэйчүүд

Эмэгтэйчүүд соёлын тодорхой салбарт голдуу ажил эрхэлдэг

Соёлын боловсрол ба сургалтад

60%

Ном, хэвлэлд

54%

Дуу, дүрс бичлэг болон интерактив хэвлэл мэдээлэлд

26%

Загвар, бүтээлч үйлчилгээнд

33%

Эмэгтэйчүүд гол төлөв хагас цагаар ажиллаж байна

Эмэгтэйчүүд

27.7%

Эрэгтэйчүүд

17.5%

Эмэгтэйчүүд эрчүүдээс бага цалин авч байна.

75 ¢ Хойд Америкт музейн эрэгтэй захирлуудын авч буй доллар тутмын

Европт эмэгтэй найруулагчийн бүтээсэн киног дэмжсэн зарцуулалт

16%

Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо бага байна

Соёлын сайд нарын

34% эмэгтэй

Үндэсний урлагийн зөвлөлийн захирлуудын

31% эмэгтэй

ХӨГЖИЛ ДЭВШИЛ БАЙГАА ХЭДИЙ Ч ИЛҮҮ ИХ ХҮЧИН ЧАРМАЙЛТ ГАРГАХ ХЭРЭГТЭЙ. ҮҮНД:

- жендэрийн үзэл баримтлалыг соёлын бүх бодлого, арга хэмжээнд тусгах
- хүйсээр зааглаасан тоон үзүүлэлтийн чанар, боломжийг нэмэгдүүлэх
- боломж бололцоо, санхүүжилтийн тэгш хүртээмжийг хангах
- эмэгтэйчүүдийг соёлын орчин үеийн илэрхийллийг бүтээгч, найруулагч хэмээн үзэж дэмжих

Design: infographic.ly

Бүлэг 9

Жендэрийн тэгш байдал: Дутагдаж буй ажил

Амму Жозеф

ГОЛ САНААНУУД

- ***Жендэрийн олон талт ялгаа дэлхийн дийлэнх хэсэгт соёлын бүх хүрээнд оршиж байна. Ажиллах хүчин дэх эмэгтэйчүүдийн төлөөлөл, ялангуяа бүтээлч гол дүр авах болон шийдвэр гаргах түвшинд асар бага байгаад зогсохгүй нөөц хүртэх боломж хомс, цалингийн бодит зөрүүтэй тулгарч байна.***
- ***Ялгаатай байдлыг сайтар ухамсарлахгүй байгаа хэдий ч соёлын илэрхийллийн олон төрөлд жинхэнээсээ хүрэхийг зорьж байгаа бол хэрэгцээг тодорхойлж түүнийг шийдвэрлэх нь чухал юм.***
- ***Жендэрийн тэгш байдлыг соёлын илэрхийллийг бүтээгч, үйлдвэрлэгч, хүртэх зэргээр соёлын үйл ажиллагаанд оролцож буй иргэдийн дунд идэвхтэй дэмжихгүйгээр 2005 оны конвенцийг зохистой хэрэгжүүлж чадахгүй.***
- ***Конвенциор тодорхойлсон жендэрийн тэгш байдлын зорилго нь онцгой арга хэрэгслийг шаардахаас гадна жендэрийн үзэл баримтлалыг соёлын бодлого, арга хэмжээнд тусгахыг чухалчилдаг.***
- ***Хүйсээр зааглан системтэй бүрдүүлсэн үндэсний болон дэлхийн мэдээлэлд соёлын илэрхийллийн жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн хяналт шинжилгээний үйл явц, бодлого, төлөвлөгөөг мэдээлэх, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, нөхцөл байдлыг тодорхойлох зайлшгүй шаардлагатай.***
- ***Эмэгтэйчүүд соёлын амьдралын бүх хүрээнд бүтээгч, үйлдвэрлэгч, түгнчлэн иргэн, хэрэглэгчийн хувьд оролцох боломжгүй тохиолдолд соёлын илэрхийллийн олон төрөл маань ойлгомжгүй үлдэнэ.***

Гурав дахь зуунд эмэгтэй уран бүтээлчид хөгжих боломжоор хангагдаж хороо болон шүүгчдийн дунд нэр нөлөөтэй, ялгаваргүй шударга цалин хөлс авч ажил, гэр бүл хоорондын тэнцвэрээ сайтар хадгалж явах үүрэгтэй болохыг дурдахгүйгээр өнгөрөх ёсгүй.

Моника Груттерс

Германы Соёл, хэвлэл мэдээллийн төрийн сайд

УРАН БҮТЭЭЛЧИД РҮҮ ХАЛДСАН ТОХИОЛДОЛ ДЭЛХИЙ ДАХИНД ӨСӨХ ХАНДЛАГАТАЙ БАЙНА

2014



90 ТОХИОЛДОЛ

2015



340 ТОХИОЛДОЛ

2016



430 ТОХИОЛДОЛ

ДИЙЛЭНХ ТОХИОЛДОЛ ХӨГЖИМЧДИЙН ЭСРЭГ ГАРСАН БАЙНА

86 ноцтой тохиолдол гарсан

ГЭВЧ БҮТЭЭН ТУУРВИХ ЭРХ ЧӨЛӨӨ НЬ ХЯЗГААРЛАГДМАЛ НӨХЦӨЛД БУЙ УРАН БҮТЭЭЛЧДИЙГ ДЭМЖИХ САНААЧЛАГА НЭМЭГДСЭЭР БАЙНА

Оршин суух ба аюулгүй газар

2006 оноос хойш

170 уран бүтээлчдийг

80 хот хүлээн авсан

Дэлхийн 100 гаруй байгууллагууд

- яаралтай тусламжийн хандив, тэтгэлэг
- хууль эрх зүйн нөөц бололцоо
- байрлах боломжууд
- дахин суурьших үйлчилгээгээр хангаж байна

Уран бүтээлчдийн нийгэм, эдийн засгийн эрхийг дэмжихэд чиглэсэн шинэ хууль тогтоомжийг нэн ялангуяа Африкт баталж хэрэгжүүлж байна.

УРАН БҮТЭЭЛЧДИЙГ САЙТАР ХАМГААЛАХЫН ТУЛД ИХ ЗҮЙЛИЙГ ХИЙХ ШААРДЛАГАТАЙ.

- уран бүтээлчдийн статусыг соёлын бодлогод тодорхой тусгах
- эрх зүйн мэдлэг, эх сурвалжид нэвтрэх боломжийг нэмэгдүүлэх
- уран бүтээлчид болон хүний эрхийг хамгаалагчид хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх
- хяналт шинжилгээ, өмгөөллийг сайжруулах

Design: infographic.ly

Бүлэг 10

Бүтээх, сэтгэн бодох эрх чөлөөг хөхиүлэн дэмжих нь

Сара Вайт

ГОЛ САНААНУУД

- ***Төрийн болон төрийн бус оролцогчдын үйлдлээр 2016 онд урлагийн эрх чөлөөнд халдсан тохиолдол гол төлөв хөгжимчдийн эсрэг гарсан нь 2014, 2015 оныхтой харьцуулахад өссөн үзүүлэлт юм.***
- ***Урлагийн илэрхийллийг хамгаалах болон хөхиүлэн дэмжихийн ач холбогдлыг ойлгож ухамсарлахад ахиц дэвшил гарсан. Зарим улс орнууд үндсэн эрх чөлөөг хүндлэх талаар хууль тогтоомжиндоо өөрчлөлт оруулахаар үүрэг амлалт авсан.***
- ***Уран бүтээлчдийн нийгэм, эдийн засгийн эрхийг дэмжих арга хэрэгсэл үндэсний хууль тогтоомжид тэр дундаа Африкт ихээхэн өсөн нэмэгдэж байна.***
- ***Террорист халдлага, үндэсний аюулгүй байдал, гэмт хэргийн шинжтэй гүжирдлэг, шашин, „уламжлалт үнэт зүйлс"ийн талаарх хууль тогтоомжийг уран бүтээлийн болон чөлөөт илэрхийлийн бусад хэлбэрийг тогтооход ашиглаж байна.***
- ***Уран бүтээлийн эрх чөлөөг хянан шинжлэх, өмгөөлөх ажил түүнд оролцох байгууллагуудын тоо, чадамж АНУ-ыг оролцуулан өссөн байна.***
- ***Уран бүтээлээ туурвих эрсдэлд буй уран бүтээлчдийн аюулгүй байдлыг хангах хотуудын тоо нэмэгдсээр дэлхийд 80 гаруй болж байна.***

Тиймээс, юунаас ч илүүтэй 2005 оны конвенцийг уран бүтээлийн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, биднийг хүнлэг болгож буй бүтээлч байдлыг тэтгэж, дэмжиж, хамгаалах бодлогыг бий болгоход ерөнхий суурь зарчим болгох хэрэгтэй.

Дээяа Хан

Кино найруулагч, ЮНЕСКО-ийн уран бүтээлийн эрх чөлөө, бүтээлч байдлын асуудал эрхэлсэн сайн санааны элч

Нэгдсэн Үндэстний Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагаас 2017 онд эрхлэн хэвлүүлэв

7, place de Fontenoy, 75352 Paris 07 SP, France

© ЮНЕСКО 2017

Энэхүү хэвлэлд хандах боломж нээлттэй: (CC-BY-SA 3.0 IGO) зөвшөөрөл (http://creativecommons.org/licenses/by-sa/3.0/igo/) Хэрэглэгчид энэхүү хэвлэлтийн агуулгыг ашиглахдаа ЮНЕСКО-ийн Нээлттэй хандалтын сангийн хэрэглэх нөхцөлийг хүлээн зөвшөөрөх шаардлагатай (www.unesco.org/open-access/terms-use-ccbysa-en).

Хэвлэлтэд дурдсан тэмдэглээ болон материалын танилцуулга нь ЮНЕСКО-ийн аливаа улс, бүс нутаг, хот эсхүл газар нутаг, түүний удирдлагуудын эрх зүйн статус, түүний хил хязгаар, заагтай холбоотой ямарваа нэгэн үзэл бодлын илэрхийллийг агуулахгүй.

Энэ хэвлэлд илэрхийлж буй үзэл бодол, санаанууд нь гагцхүү зохиогчдынх бөгөөд тэдгээр нь заавал ЮНЕСКО-ийнх байх албагүй.

Гэрэл зургууд:

Хавтас Айда Мулунехийн хүндэтгэл, Этиоп ба Дэвид Кнутын төсөл, Буцах нь, 2016, Этиоп

х.8 Фиона Хардинг, Диваажинд хамтдаа амьдрах нь, 2009, Нгуен Ман Хунг, Вьетнам

х.11 nickgentry.com, Опус, 2013, Их Британи

х.13 Креатив коммонс, Нэг гуравт хуваагдах нь, кореа.нет, фликр, зөвшөөрөл CC BY 2.0, 2014

Жеон Ханы зураг, БНСУ

х.15 Креатив коммонс, зөвшөөрөл CC-BY-SA – Ker Thiossane/Слайдмедиа, 2016, Синегал

х.17 Пипилоти Рист, Пихелвальд, Уран бүтээлчийг хүндлэх нь, Хаусер ба Вирт, Лухринг Аугустин, 2015, Швейцарь

х.18 JR-art.net, Аженс ВУ-г хүндэтгэх нь, Акшн донс ла Фавела Морро да Провиденсиа, Арвре, Лун, Хоризонтал, Рио де Жанейро, 2008, Франц

х.21 Чихару Шиота, ДНА-ийн хэлэлцүүлэг, 2004, Гэрэл зургийг Сунхи Ман, ADAGP ба уран бүтээлчийг хүндэтгэх нь, Франц, 2017, Япон

х.23 Жак Баланс, Коконат Диско-Африкийн ааниа, Катрина Нуминений удирдсан жүжиг, 2011, Финлянд

х.25 Креатив коммонс, Терри Адкинс, Бүх дэлхийн ирээдүй, фликр-Маттео Биттанти, зөвшөөрөл CC BY-NC 2.0, 2015, АНУ

х.26 Креатив коммонс, Аниш Капуур, Гишүүний эрхийг хасах, сайт 1, фликр-Андим5855, зөвшөөрөл CC BY-SA 2.0, 2009, Энэтхэг

х.29 Кристин Одлунд, Амираленс Традгард, Гэрэл зургийг Жан Ваптист Берангер, Галери Риис, Кристин Одлундыг хүндэтгэх нь, 2013, Швед

х.30 Виктор Эхихаменор, Тэнгэрийн хүүхэд, 2015, Нигери

х.33 Тереса Фрайтас, Үүлэн дэх толгой, 2015, Португал

х.35 Руне Гунериусэн, Хувьсал, 04, 2005, Норвеги

CC-BY-SA зөвшөөрөлгүй гэрэл зургийг эзэмшигчийнх нь зөвшөөрөлгүйгээр хэрэглэж, худалдаж, эсвэл дахин үйлдвэрлэж болохгүй.

График загвар болон хавтасны загварыг Корин Хэйворт

ЮНЕСКО-д хэвлүүлэв

Sweden Sverige

Швед улсын дэмжлэгтэйгээр хэвлэгдэв.

United Nations Educational, Scientific and Cultural Organization
Beijing Office
Office of the Representative to Democratic People's Republic of Korea, Japan, Mongolia, People's Republic of China, and Republic of Korea

ЮНЕСКО-ийн Бээжин дэх Төлөөлөгчийн газар Монгол хэлнээ хөрвүүлэх төслийн зохицуулагчаар ажиллав.

Нэгдсэн Үндэстний Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллага
ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний Комисс

Энэхүү номыг ЮНЕСКО-ийн санхүүжилтээр ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний Комисс монгол хэлнээ хэвлүүлэв.

United Nations
Educational, Scientific and
Cultural Organization

Diversity of
Cultural Expressions

СОЁЛЫН БОДЛОГЫГ ДАХИН ТОДОРХОЙЛОХ НЬ

ЮНЕСКО 2017

Энэхүү дэлхийн цуврал тайланг Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай (2005) ЮНЕСКО-ийн конвенцийн хэрэгжилтийг хянах зорилгоор гаргадаг. Конвенцийн хэрэгжилтийн үйл явц нь Нэгдсэн Үндэстний Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөрийн зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд хэрхэн хувь нэмэр оруулж буйн нотолгоо болох юм.

Анхны дэлхийн тайлан 2015 онд хэвлэгдэн гарснаас хойш 2005 оны конвенцийг хэрэгжүүлэх чиглэлд ямар ахиц дэвшил гарсныг 2018 оны тайланд тусгасан.

Конвенцийн оролцогч талуудын зүгээс дөрвөн жил тутамд илгээдэг хугацаат тайланд хийсэн дүн шинжилгээ болон шинэ ололт, нээлтэд тулгуурлан дэлхийн болон улс орнуудын түвшинд хяналт шинжилгээний 10 хэсэгт бодлогын өөрчлөлт хийхэд 2005 оны конвенц хэрхэн хөшүүрэг болж байгааг энэ тайланд хамруулсан. Хүний үндсэн эрх, эрх чөлөөнд суурилан соёлын бодлогыг цахим орчны хурдацтай өөрчлөлтөд тохируулах замаар цаашид авч хэрэгжүүлэх бодлогын цогц зөвлөмжүүдийг тусгасан.

Хамтдаа тараагдах дэлхийн тайлангийн хоёр хувилбар нь соёлын бодлого боловсруулах болон хөгжлийн төлөө бүтээлч байдлыг урагшлуулахад шинэ бөгөөд үнэ цэнтэй нотолгооны суурь эхлэл юм.

2018

http://en.unesco.org/creativity/